



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/68

Улаанбаатар хот

Тушаал хүчингүйд тооцох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 6 сарын 16-ны өдрийн 136, 137 дугаар улсын байцаагчийн албан шаардлагуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр батлагдсан А60, А61, А62, А63, А64, А65 дугаар тушаалуудыг тус тус хүчингүйд тооцсугай.
2. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Азиа пасифик секьюритис ҮЦК” ХХК, “Батс ҮЦК” ХХК, “Бумбат алтай ҮЦК” ХХК, “Гендекс ҮЦК” ХХК, “Монгол хувьцаа ҮЦК” ХХК, “Эф Си Экс ҮЦК” ХХК компаниудын үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үгийг нээх ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-д даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

1520020136